



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар Д/2027

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын  
Эрдмийн оргил цогцолбор сургуулийн  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 8,800,000 (найман сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн оргил цогцолбор сургууль (О.Оюунтуяа)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн оргил цогцолбор сургууль (О.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000929



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалын хавсралт

Байгууллага: Налайх дүүргийн Эрдмийн оргил цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Сурагчийн ширээ сандал	Төмөр хөлтэй модон тавцантай	2020	шинэ	хос	40	220,000	8,800,000	Хандив	Сургуулийн 1990 оны төгсөгчид
								<b>8,800,000</b>		

**Дүн**